

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2021 оны 11 сарын 29 ны өдөр

№ 21/07-529

Багануурдүүрэг

Энэхүү гэрээг нэг талаас /РД2008572/ “БАГАНУУР” ХК /цаашид “Худалдан авагч тал” гэх/-ийг төлөөлж Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн дарга С.Батхишиг, нөгөө талаас /РД6293433/ “ЦАМЦ МОД” ХХК /цаашид “Худалдагч тал” гэх/-ийг төлөөлж Ө.Батэрдэнэ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

1.1 Энэхүү гэрээгээр худалдагч нь стандарт, чанарын шаардлага хангасан аливаа эрхийн доголдолгүй дор дурьдсан сэлбэгийг /цаашид бараа гэх/ худалдан авагчийн заасан хугацаанд нийлүүлэх, худалдан авагч нь барааг хүлээн авч гэрээнд заасан үнийг төлөхтэй холбоотойгоор талуудын хооронд үүсэх эрх, үүрэг, хариуцлага маргаан шийдвэрлэх болон үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой үүссэн харилцааг зохицуулна. Үүнд:

№	Бараа материалын нэр /эдийн дугаар/	Хэ мж их	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Холхивч 3640 /орос/	ш	8	5 000 000-00	40 000 000-00
2	Холхивч 3536 /орос/	ш	2	3 500 000-00	7 000 000-00
	Бүгд				47 000 000-00
	НӨАТ				4 700 000-00
	Нийт				51 700 000-00

Хоёр. Нийлүүлэх хугацаа, нөхцөл

- 2.1. Худалдагч нь гэрээ хийгдсэнээс хойш 60 хоногт багтаан тоо ширхэгээр хугацаанд нь нийлүүлж худалдан авагчид хүлээлгэн өгч бараатай холбоотой зохих мэдээллийг өгнө.
- 2.2. Худалдан авагч, худалдагч талууд бараа материалыг хүлээлцсэн санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн үйлдэнэ.
- 2.3. Худалдагчийн буруугаас шалтгаалаагүй нийгэм, эдийн засгийн болон гэнэтийн буюу давагдашгүй нөхцөл байдлын улмаас барааг хугацаандаа нийлүүлээгүй бол худалдагч тал аливаа хариуцлага хүлээхгүй.

Гурав. Талуудын эрх, үүрэг

- 3.1. Худалдагч нь чанарын шаардлага хангасан, эрхийн зөрчилгүй барааг худалдан авагч талд хүлээлгэн өгнө.
- 3.2. Худалдагч нь хүлээлцэх актаар хүлээлгэн өгч, өмчлөлд нь бүрэн шилжүүлсэн барааг худалдан авагчаас буцааж авахгүй.
- 3.3. Бараа нийлүүлэх хугацаа хэтэрсэн тохиолдолд худалдагч хэтэрсэн хоног бүрт алданга тооцохгүй.

Дөрөв. Баталгаа

- 4.1. Худалдагч тал нь нийлүүлж буй бараандаа 6 сарын баталгаа гаргана.
- 4.2. Баталгаанд барааны энгийн /2 тал харилцан тохиролцсон/ эвдрэлүүд хамаарахгүй.

БАГАНУУР Х
ГЭРЭЭГ БҮРТГ
2021 оны 11 сар 29
3

4.3. Баталгаат хугацаанд нийлүүлсэн барааны чанар, стандартын шаардлага хангахгүй нь тогтоогдсон тохиолдолд барааг буцаана.

Тав. Төлбөрийн нөхцөл

5.1. Энэхүү гэрээний 1.1-д заасан барааны үнийн нийт дүн /НӨАТ-тэй/ 51700000 төгрөгийг худалдагч талын ГОЛОМТ банкны 14151158960 тоот дансанд шилжүүлэх эсвэл бэлнээр төлнө.

Зургаа. Бусад зүйл

- 6.1. Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
6.2. Энэхүү гэрээг 3 хувь үйлдсэн бөгөөд эх тус бүр нь адил хүчин төгөлдөр байна.
6.3. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцож нэмэлт оруулж гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хууль зүйн хүчинтэй.
6.4. Гэрээтэй холбоотой аливаа маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд боломжгүй гэж үзвэл шүүхэд хандан шийдвэрлүүлж болно.

Гэрээ байгуулсан:

Худалдан авагч тал:

Хаяг: Монгол улс,
Улаанбаатар хот, Багануур дүүрэг
Багануур ХК,
Утас: 70210114, Факс: 70213130

Худалдагчийн тал:

Хаяг :Монгол улс, Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, 18-р хороо
Цамц мод ХХК
Утас: 95953183

Худалдан авагчийг төлөөлж:

“БАГАНУУР” ХК

Гүйцэтгэх захирал

Э.Номинчулуун

Санхүү эдийн засгийн бодлогын хэлтсийн
дарга

Д.Болд

Худалдагчийг төлөөлж:

“ЦАМЦ МОД” ХХК

Захирал

Ө.Батэрдэнэ

ЦАМЦ МОД
ХХК

1118261498
УЛААНБААТАР ХОТ

Ө.Батэрдэнэ

Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн
дарга

С.Батхишиг

Хуулийн зөвлөх

С.Сэргэлэн